



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2016 оны 7 сарын 27 өдөр

Дугаар 277

Улаанбаатар хот

Торгуулийн арга хэмжээ авах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.10.11, “Гишүүнчлэлийн журам”-ын 5 дугаар зүйлийн 5.2.2.2, гишүүн компаниудтай байгуулсан “Гишүүнчлэлийн гэрээ”-ний 2 дугаар зүйлийн 2.4.6.1, 4 дүгээр зүйлийн 4.2.3.б дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. 2016 оны хагас жилийн санхүүгийн тайлан тэнцлийг тогтоосон хугацаанд ирүүлээгүй 1 дүгээр хавсралтанд заасан нэр бүхий 20 компаниас тогтоосон хэмжээний торгуулийг нэхэмжлэн төлүүлсүгэй.
2. Энэхүү тушаал гарснаас хойш ажлын 10 хоногт багтаан торгуулийг төлж, гаргасан зөрчлийг арилгах, ногдуулсан торгуулийг дурдсан хугацаанд багтаан төлөөгүй тохиолдолд арилжаанд оролцох эрхийг хязгаарлах арга хэмжээ авахыг дээрх компаниудад тус тус анхааруулсугай.
3. Тушаалын 1-д заасан арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдуулан компаниудад нэхэмжлэх хүргүүлэхийг Санхүүгийн алба /Х.Эрдэнэбүрэн/-д даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



М.БОЛОР

Гүйцэтгэх захирлын 2016 оны 7 дугаар сарын 27-ны
өдрийн 277 тоот тушаалын хавсралт.



Торгууль төлүүлэх гишүүн компаниудын нэрс

№	Компанийн нэр	Торгуулийн хэмжээ /төг/
1	"Аргай бэст ҮЦК" ХХК	96,000
2	"Бага хээр ҮЦК" ХХК	96,000
3	"Би Би Эс Эс ҮЦК" ХХК	96,000
4	"Блэкстоун интернэйшнл ҮЦК" ХХК	96,000
5	"Гацуурт трейд ҮЦК" ХХК	96,000
6	"Гендекс ҮЦК" ХХК	96,000
7	"Гранддевелопмент ҮЦК" ХХК	96,000
8	"Говийн ноён нуруу ҮЦК" ХХК	96,000
9	"Догсон" ХХК	96,000
10	"Зэт жи би ҮЦК" ХХК	96,000
11	"Зюс капитал ҮЦК" ХХК	96,000
12	"Капитал маркет корпораци ҮЦК" ХХК	96,000
13	"Масдак ҮЦК" ХХК	96,000
14	"Нэйшнл секюритис ҮЦК" ХХК	96,000
15	"Превалент ҮЦК" ХХК	96,000
16	"Таван богд ҮЦК" ХХК	96,000
17	"Тэсо инвэстмент ҮЦК" ХХК	96,000
18	"Финанс линк групп ҮЦК" ХХК	96,000
19	"Хүннү эмпайр ҮЦК" ХХК	96,000
20	"Эф си экс ҮЦК" ХХК	96,000

-----oOo-----